



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 2/86

Мандалговь

Г

Комисс томилох тухай

7

Монгол Улсын “Төрийн нууцын тухай” хуулийн 14.1.1, 14.3, “Архивын тухай” хуулийн 9.4.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 213 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Төрийн нууцыг хамгаалах журам”, Засгийн газрын 1999 оны 164 дүгээр тогтоолоор батлагдсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын хяналтын дүрэм”, “Монгол улсын Зэвсэгт хүчний нууцыг хамгаалах журам”-ын 7 бүлгийн 26, 27 дугаар заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг: Цэргийн штабын 2017 оны эхний хагас жилийн нууцын тооллого явуулах комиссийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Цэргийн штабын дарга, хурандаа Б.Амаржаргал

Гишүүдэд:

- Цэргийн штабын ОНХ, сургалтын офицер хошууч Ш.Гансүх
- СТСХ-ийн төсвийн ахлах мэргэжилтэн, Улсын дайчилгааны мэргэжилтэн Н.Сүхбаатар

Хоёр: Цэргийн штабт ашиглагдан хадгалагдаж байгаа маш нууц, нууц бичиг баримтууд болон архив, албан хэрэг хөтлөлт, баримтын хадгалалтыг 2017 оны 06 дугаар сарын 02-ноос 04-ны хооронд нэг бүрчлэн тоолж, шалган, акт үйлдэн холбогдох байгууллагад нь тооллогын актыг явуулахыг Цэргийн штабын дарга хурандаа Б.Амаржаргалд үүрэг болгосугай.

ДАРГА

О.ЧУЛУУНБАТ

0200299